



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨВӨРХАНГАЙ АЗЗА ТӨХК-ний 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2023/02/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас:
www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2023 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг:
Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АЗЗА	Авто зам засвар арчлалт



ӨВӨРХАНГАЙ АЗЗА ТӨХК-ИЙН
ДАРГА Д.ЛХАМ-ОРОЛМАА ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.09 № 118
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 307-р тогтоолоор 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг 39.5 сая төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Авлага, өглөгийг барагдуулаагүй, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулаагүй, эргэлтийн хөрөнгийн тооллогыг Сангийн сайдын батлагдсан маягтын дагуу бүртгэл хөтлөөгүй, тооллогын комиссын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, малын өсөлт, хорогдлын тайлан гаргаагүй, томилолтын зардлыг 6 хүнд илүү тооцож олгосон, ирсэн, явсан хугацааг баталгаажуулаагүй зэрэг зөрчил байна. Бусад мэдээллийн талаар онцлог анхаарал татсан зүйлгүй байна

015030625

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	529,138,950.35	378,656,854.89
1.1.2. Дансны авлага	41,507,270.00	62,906,510.00
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	3,697,604.51	
1.1.4. Бусад авлага	11,294,452.67	1,860,864.67
1.1.6. Бараа материал	210,686,747.25	269,844,688.64
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	796,325,024.77	713,268,918.19
1.2.1 Үндсэн хөрөнгө	1,037,548,099.49	1,099,538,597.88
1.2.2 Биет бус хөрөнгө	490,674,500.00	490,440,500.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,528,222,599.49	1,589,979,097.88
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,324,547,624.26	2,303,248,016.07
2.1.1.1 Дансны өглөг	107,092,004.98	27,654,452.97
2.1.1.3 Татварын өр	9,192,444.41	32,403,913.07
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	116,284,449.39	60,058,366.04
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	160,001,535.00	160,001,535.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	160,001,535.00	160,001,535.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	276,285,984.39	220,059,901.04
2.3 Эздийн өмч	1,265,365,670.17	1,265,365,670.17
2.3.1 Төрийн	1,265,365,670.17	1,265,365,670.17
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	358,891,139.51	358,891,139.51
2.3.9 Хуримтлагдсан ашиг	424,004,830.19	458,931,305.35
2.3.11 Эздийн өмчийн дүн	2,048,261,639.87	2,083,188,115.03
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,324,547,624.25	2,303,248,016.07

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтийн нэр		Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1	Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	2,343,350,200.00	2,882,871,633.63
2	.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,959,429,072.68	2,403,153,780.15
3	Нийт ашиг (алдагдал)	383,921,127.32	479,717,853.48
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	357,000.00	12,300,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	56,091,805.00	60,191,786.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	217,480,363.94	261,825,193.78
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	22,942,617.50	87,305,218.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	87,763,340.88	82,695,654.86
19	Орлогын татварын зардал	8,776,334.09	8,269,179.70
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	78,987,006.79	74,426,475.16

21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	78,987,006.79	74,426,475.16
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	78,987,006.79	74,426,475.16
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	1,257,949,000.63	358,891,139.51	0.00	424,004,830.19	2,040,844,970.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	34,926,475.16	34,926,475.16
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,265,365,670.17	358,891,139.51	0.00	0.00	1,624,256,809.68
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	34,926,475.16	34,926,475.16
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	458,931,305.35	0.00	458,931,305.35
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,265,365,670.17	358,891,139.51	0.00	458,931,305.35	2,083,188,115.03

Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,672,969,066.00	3,247,185,885.00
1.1 Мөнгөн орлогын дүн	2,672,969,066.00	3,247,185,885.00
Бусад мөнгөн орлого	2,672,969,066.00	3,247,185,885.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	2,544,592,618.03	3,397,667,980.46
Ажиллагчдад төлсөн	340,826,020.20	361,300,096.50
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	148,979,608.81	158,890,098.17
Бараа материал худалдан авахад төлсөн	1,507,121,116.52	2,521,286,560.00
Татварын байгууллагад төлсөн	180,486,930.10	184,291,825.79
Бусад мөнгөн зарлага	367,178,942.40	171,899,400.00
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	128,376,447.97	(150,482,095.46)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	128,376,447.97	(150,482,095.46)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	400,762,502.38	529,138,950.35
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	529,138,950.35	378,656,854.89

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Өвөрхангай АЗЗА ТӨХК –ний зорилго нь зам засвар арчлалтын ажлыг чанарын өндөр түвшинд, техник технологийн дагуу хөдөлмөр аюулгүй байдлыг ханган ажиллаж ард иргэдийг ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Автозамын тухай хуулийн зарим заалтад өөрчлөлт орсон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлт ороогүй бөгөөд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль шинээр батлагдсан байна.

Өвөрхангай АЗЗА ТӨХК –ний удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ий захирлын 2021 оны 06 сарын 17-ны өдрийн А/12 тоот тушаалаар Дотоод хяналтын комисс томилж ажиллах журам комиссын бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж мөрдөн ажиллаж байна. Тайлант онд 4 ажил хийхээр төлөвлөж захирлын тушаалаар дотоод хяналт шалгалтын удирдамж боловсруулж хэрэгжүүлж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ий 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус Өвөрхангай АЗЗА ТӨХК-ний мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.


Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,3 сая төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	529138,9	378656,9	150482,0
Авлага	56499,4	64767,4	-8268,0
Бараа материал	210686,7	269844,7	-59158,0
Үндсэн хөрөнгө	1528222,6	1589979,1	-61756,5
Нийт хөрөнгө	2324547,6	2303248,1	21299,5
Өр төлбөр	276286,0	220059,9	56226,1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2048261,6	2083188,2	-34926,6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2324547,6	2303248,1	21299,5

2022 оны санхүүгийн тайланд тусгасан авлагыг үүссэн хугацаагаар харуулбал дараах байдалтай байна.

АВЛАГА



Урт хугацаат өр төлбөр 2016 онд Кувейтийн сангаас нийлүүлсэн 160001,5 мянган төгрөгийн 7 төрлийн техник байгаа бөгөөд үлдэх өртөг 1631,5 мянган төгрөг болсон байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 659 тоот тогтоолын дагуу өөрийн хөрөнгөөр суудлын автомашин 1ш, траллер чирэгч 1ш ханын шкаф, сандал, ширээ, компьютер, канон зэрэг хөрөнгийг бэлтгэсэн. Мөн ТӨБЗГ-ын А1/2644 албан тоот бичгээр 36 нэр төрлийн 31392,5 мянган төгрөгийн эд хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэн. ТӨБЗГ-ын 531 тоот тогтоолоор 10 нэр төрлийн тээврийн хэрэгсэл, машин механизмыг, ТӨБЗГ-ын А1/2658 тоот албан бичгээр 7 нэр төрлийн 3728,0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг данснаас хассан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2022 он	
			Төлөвлөгөө мян.төг	Гүйцэтгэл мян.төг
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			
Үүнээс	Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	2,000,000.00	2,255,716.80
	Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	мян.төг	400,000.00	627,154.80
2	Нийт орлого	мян.төг	2,400,000.00	2,882,871.60
3	Нийт зардал	мян.төг	2,304,000.00	2,800,176.00
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	340,353.60	261,825.20
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	96,000.00	82,695.60
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	86,400.00	74,426.50
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	324,000.00	338,110.10
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	33,090.20	39,500.00
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	48	47
9	Нийт цалингийн сан	мян.төг	560,000.00	567,004.90
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	972.2	1,005.30
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.96	0.97
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	192,400.00	192,400.00
13	Нийт авлага	мян.төг	75,000.00	64,767.40
14	Нийт өглөг	мян.төг	210,001.50	220,059.90
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	50,000.00	60,058.40
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	160,001.50	160,001.50

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 659 дугаар тогтоолоор баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2400.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2304.0 сая төгрөгөөр, 86.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 192.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2882.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2800.2 сая төгрөгийн зардал гарган, 74.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 79,0 сая төгрөг, түрээсийн орлогын 40 хувь буюу 39.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Өвөрхангай АЗЗА ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компани/ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны зардлын 28.1 сая төгрөгөөс 75 хувиар буюу 21.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн *тогтоох шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Энэ хуулийн хүрээнд томилолтын зардлыг олгохдоо илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүрүүлсэн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	14853.6	2	14853.6	100
Зөвлөмж	1	0	1		100
Нийт дүн	3	14853.6	3	14853.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байдлаар төлөвлөн зарцуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 293554,7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 412,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8145,4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 284997,3 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Дотоод албан томилолтын 412000 төгрөгийн зардлыг илүү олгосон.

Илрүүлэлт:

Томилолтын зардлыг 6 хүнд илүү тооцох олгосон, ирсэн, явсан хугацааг баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дотоод албан томилолтын зардал илүү олгосон 412000 төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Төрийн сан дахь Орон нутгийн ерөнхий орлогын 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх акт хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулаагүй байна.

Илрүүлэлт: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулаагүй

1. Тоглолтын билет худалдан авсан -250.0
2. Биеийн тамирын хувцас худалдан авсан-2719.4

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- 3. Спортын арга хэмжээ зохион байгуулж шагнал олгосон-1449.0
- 4. Хөлдөөгч худалдан авсан-1900.0
- 5. 9292 УБЗ дугаартай тээврийн хэрэгслийн торгууль төлсөн-1277.0
- 6. Заалны тооцоо- 550.0 мянган төгрөгийн зардал гарсан байна

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1:

Малын өсөлт, хорогдлын тайлан гаргаагүй.

Өгсөн зөвлөмж 1:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна заалтыг зөрчсөн бөгөөд малын өсөлт, хорогдлын тайланг тогтмол гаргаж хэвших.

Илрүүлэлт 2:

Эргэлтийн хөрөнгийн тооллогыг Сангийн сайдын батлагдсан маягтын дагуу бүртгэл хөтлөөгүй, тооллогын комиссын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж 2:

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347-р тушаалыг хэрэгжүүлж батлагдсан маягтын дагуу тооллогын бүртгэлийг хөтлөх.

Илрүүлэлт 3:

Насжилт урттай авлага, урт хугацаат өглөгийг барагдуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж 3:

Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өглөгийг барагдуулаагүй	1	224768,9					1	224768,9				
2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулаагүй	1	8145,4			1	8145,4						
Эргэлтийн хөрөнгийн тооллогыг Сангийн сайдын батлагдсан маягтын дагуу бүртгэл хөтлөөгүй, тооллогын комиссын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна	1						1					
Малын өсөлт, хорогдлын тайлан гаргаагүй байна.	1	170,0					1	170,0				
Томилолтын зардлыг 6 хүнд илүү тооцох олгосон, ирсэн, явсан хугацааг баталгаажуулаагүй байна.	1	412,0	1	412,0								
Дүн	5	233496,3	1	412,0	1	8145,4	3	233496,3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 43/0157035/001-2023/02/111-071 т.г. Арвайхээр сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтын 412000 төгрөгийн зардлыг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д заасан "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноор үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дотоод албан томилолтын зардал илүү олгосон 412000 төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Төрийн сан дахь Орон нутгийн ерөнхий орлогын 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2023 оны 6 дүгээр сарын 01-ний дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өвөрхангай АЗЗА ТӨХК-ний дарга Д.Лхам-Оролмаа, нягтлан бодогч С.Төмөрбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
АУДИТОР Ц.МӨНХЗАЯА



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 2023/03/03/10/АМ-2023/03/10-017-Т/У Арвайхээр сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулаагүй байна. Үүнд:

1. Тоглолтын билет худалдан авсан -250.0
2. Биеийн тамирын хувцас худалдан авсан-2719.4
3. Спортын арга хэмжээ зохион байгуулж шагнал олгосон-1449.0
4. Хөлдөөгч худалдан авсан-1900.0
5. 9292 УБЗ дугаартай тээврийн хэрэгслийн торгууль төлсөн-1277.0
6. Заалны тооцоо- 550.0 мянган төгрөгийн зардал гарсан байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-д "Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох, 8-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өвөрхангай АЗЗА ТӨХК-ний дарга Д.Лхам-Оролмаа, нягтлан бодогч С.Төмөрбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
АУДИТОР Ц.МӨНХЗАЯА